



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/374

Хэрлэн сум

Г Дуудлага худалдаа зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Амьтны тухай хуулийн 29¹ дүгээр зүйл, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 5.6.1, 8.1 дүгээр зүйлийн 8.1.23 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийн удирдамжыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах барих тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааг хууль журманд нийцүүлэн зохион байгуулж дуудлага худалдааны тайлан мэдээг тайлагнахыг Ажлын хэсгийн ахлагч, Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга (Г.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ